



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 05 өдөр

Дугаар А/45

Алтрага

Хүлээж авах хяналт тавих
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн "Сумын төвийн зам засвар"-ын ажлыг хүлээж авах, хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Мөнхбат
(Бэлтэс 5 дугаар багийн Засаг дарга)
Гишүүн: Ц.Хишигбаяр
(Нягтлан бодогч)
Нарийн бичгийн дарга: Д.Бямбадалай
(Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн)

2.2024 оны сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн "Сумын төвийн зам засвар"-ын ажлыг хууль журмын хүрээнд хүлээж авахыг Ажлын хэсгийн ахлагч (Б.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ОДСЭР

Document-Zahiramg

6729010100